

## **АЖЛЫН БАЙР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИУЛАЛТААР ӨРӨӨ ТҮРЭЭСЛҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ**

201.. оны ....дугаар сарын ... өдөр

№

Улаанбаатар хот

Нэг талаас “.....” ХХКомпани /цаашид “түрээслүүлэгч” гэх/, нөгөө талаас .....тоотод оршин суугч, иргэний ..... дугаарын үнэмлэх, .....дугаарын регистртэй ..... овогтой ..... /цаашид “түрээслэгч” гэх/, цаашид хамтад нь “талууд” гэх нар харилцан тохиролцож дор дурьдсан нөхцлөөр энэхүү гэрээг байгуулав.

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Түрээслэгч, түрээслүүлэгч талууд харилцан тохиролцож ..... байрлах “.....” ХХК-ийн эзэмшлийн конторын зориулалттай барилгын подвалын.....м<sup>2</sup> талбайтай өрөөг нэг жилийн хугацаатайгаар ашиглуулах болон түрээслэгч, түрээслүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлагыг тогтооход энэ гэрээний зорилго оршино.

1.2.Түрээслэгч нь түрээсэлсэн талбайнхаа ашиглалттай холбоотой хэрэглээний зардал /дулаан, ус, цахилгаан, хог хаягдал гэх мэт/ өөрөө хариуцах бөгөөд түрээслүүлэгч талд төлж байгаа түрээсийн төлбөрт хэрэглээний зардал оролцоогүй болно.

1.3.....

### **ХОЁР. ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

2.1.Түрээсэлж байгаа тухайн талбайн ашиглалтын бүрэн бүтэн байдалд хяналт тавих, тухайн түрээслэгчид саналаа уламжлах, шаардлага тавих, түрээсийн байрыг гэрээнд заасан нөхцлийн дагуу ашиглаж байгаа эсэхийг сар тутамд шалгах,

2.2. Тухайн түрээслүүлж буй байр болон инженерийн байгууламжийн засвар үйлчилгээ хийхийг шаардах эрхтэй.

### **ГУРАВ. ТҮРЭЭСЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

3.1. Түрээсэлж байгаа талбайн бүрэн бүтэн байдлыг гэрээний хугацаанд бүрэн хариуцна.

3.2. Түрээсийн байрыг ариун цэврийн шаардлага хангахуйц байлгах, гал түймрийн аюулгүй байдлыг хангах, цахилгаан, дулааныг зохих журмын дагуу ашиглах.

3.3. Түрээсэлж байгаа талбайд ямар нэгэн засвар үйлчилгээ хийх буюу хана, таазанд хүнд оврын техник, мөн эд хэрэглэл байрлуулах бол түрээслүүлэгч талд албан ёсоор мэдэгдэнэ.

3.4. ....

### **ДӨРӨВ. ТӨЛБӨР ТООЦОО**

4.1. Түрээсийн байранд эхний 2 сард засвар үйлчилгээ хийх тул 3 дахь сараас түрээсийн төлбөрийг тооцно. Ингэхдээ:

Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 3 дахь сард – 500 000 төгрөг,

4 дахь сард – 600 000 төгрөг

5 дахь сард- төгрөгөөр тооцно. **Г.м харилцан**

#### **тохиролцсон нөхцөлийн дагуу бичих**

4.2.Түрээсийн төлбөрөө сар бүрийн эхний 15 хоногт багтаан төлнө.

4.3. ....

*Үргэлжлэл бий ....*